



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 229,487,438.91 (хоёр зуун хорин есөн сая дөрвөн зуун наян долоон мянга дөрвөн зуун гучин найман төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 51,296,629.46 (тавин нэгэн сая хоёр зуун ерэн зургаан мянга зургаан зуун хорин есөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Үл хөдлөх хөрөнгийн доорх газар эзэмших эрхийг компанийн нэр дээр хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001190
15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
...278... дугаар тогтоолын хавсралт

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо/дахин үнэлсэн огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Цэвэрлэх 110/35/10 дэд станцын барилга	1987.12.31/2018.12.31	м.кв	404.44	195,185,503.19	44,468,984.44	150,716,518.75
2	Аккумуляторын байрны хийц /Цэвэрлэх/	2011.09.30/2018.12.31	м.кв	52.63	34,301,935.72	6,827,645.02	27,474,290.70
	Нийт дүн				229,487,438.91	51,296,629.46	178,190,809.45
					(хоёр зуун хорин есөн сая дөрвөн зуун наян долоон мянга дөрвөн зуун наян долоон мянга дөрвөн зуун гучин найман төгрөг ерэн нэгэн мөнгө)	(тавин нэгэн сая хоёр зуун ерэн зургаан мянга зургаан зуун хорин есөн төгрөг дөчин зургаан мөнгө)	(нэг зуун далан найман сая нэг зуун ерэн мянга найман зуун есөн төгрөг дөчин таван мөнгө)